

СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/41

Баруун-Урт сум

Ажлын байрны дүгнэлт хийх
шинжээч томилох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.11, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 400 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Баруун-Урт сумын 4 дугаар багт байрлах Өөлд-Ашид ХХК-ны Ашид эмийн сангийн байршил өөрчлөгдөж байгаа тул шинээр орж байгаа байранд үйл ажиллагаа явуулах ажлын байранд тавигдах стандарт шаардлага, шалгуурын хангалтад хяналт шалгалт хийх шинжээчээр /Д.Барцэцэг/-ийг томилсугай.

2. Хяналт үнэлгээг 2022 оны 06 дугаар сарын 22-оос 5 хоногт багтаан хийж, гарсан дүгнэлтийг илтгэх хуудсаар тусгай зөвшөөрөл олгох комисст танилцуулахыг шинжээчид үүрэг болгосугай.

3. Шинжээчийн зардал 50000 /тавин мянган/ төгрөгийг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн орлогоос гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Г.Баянжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг комиссын нарийн бичгийн дарга /Ш.Жадамба/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



[Handwritten signature]

Н.БОЛОРМАА